

# ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР

## САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Тогтвортой аялал жуулчлалыг хөгжүүлэх төслийн 2025 оны санхүүгийн тайлан,  
төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

Аудитын код: САГ-2026/48/НА-СТА-ТХН

Цахим хуудас: <a href="http://www.audit.mn">www.audit.mn</a> Улаанбаатар хот 2026 он	Санхүүгийн аудитын газрын захирал, тэргүүлэх аудитор: Ц.Наранчимэг Утас: 261663 Цахим хаяг: naranchimegts@audit.gov.mn Аудитын менежер: И.Эрдэнэцэцэг Утас: 261885 Цахим хаяг: erdenetsetseg.i@audit.mn Ахлах аудитор: Б.Лхагвацэнд Утас: 261740 Цахим хаяг: lkhagvatsendb@audit.mn Гэрээгээр гүйцэтгэсэн: Бэйкер Тилли Далайван Аудит ХХК-ийн Захирал: Ц.Жигдэн Утас: 70005401 Цахим хаяг: info@btdalaivanaudit.mn
--	--

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

АГУУЛГА

1. ХАРААТ БУС АУДИТОРЫН ДҮГНЭЛТ .....	6
2. АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ .....	9
2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан .....	9
2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан .....	10
2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан .....	11
2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан .....	12
2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан .....	12
3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА .....	14
3.1 Төслийн үйл ажиллагаа .....	14
3.2 Төсөл хэрэгжүүлэх нэгжийн гадаад, дотоод орчин .....	14
3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал .....	15
3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлтүүд .....	15
3.5 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл .....	16
4. АУДИТЫН ТАЙЛАН .....	22
4.1 Ерөнхий зүйл .....	22
4.2 Материаллаг байдал .....	22
4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт .....	22
4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал .....	22
4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт .....	23
4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал .....	23
5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ .....	24
6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ .....	25

**Товчилсон үгийн жагсаалт**

АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
АХБ	Азийн Хөгжлийн Банк
ТӨААТҮГ	Төрийн өмчит аж ахуйн тооцоот үйлдвэрийн газар
ОНОХАА	Олон нийтийн оролцоотой худалдан авах ажиллагаа
УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
ХХК	Хязгаарлагдмал Хариуцлагатай Компани
ХНБЦГ	Хөвсгөл нуурын байгалийн цогцолборт газар
ХУТХГ	Хөвсгөлийн тусгай хамгаалалтын газар
ХХОАТ	Хувь хүний орлогын албан татвар
ЧХАЖЦ	Чингис хааны аялал жуулчлалын цогцолбор



## ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР

Засгийн газрын IV байр, Бага тойруу 3,  
Чингэлтэй дүүрэг, Улаанбаатар хот, 15160  
Утас: 26 04 37, Факс: (976-51) 26 42 30,  
Цахим шуудан: info@audit.gov.mn,  
Цахим хуудас: www.audit.mn

СОЁЛ, СПОРТ АЯЛАЛ ЖУУЛЧЛАЛ  
ЗАЛУУЧУУДЫН ЯАМНЫ АЯЛАЛ,  
ЖУУЛЧЛАЛЫН БОДЛОГО  
ЗОХИЦУУЛАЛТЫН ГАЗРЫН ДАРГА  
БӨГӨӨД НЭГДСЭН ТӨСӨЛ  
ХЭРЭГЖҮҮЛЭХ НЭГЖИЙН  
ТӨСЛИЙН ЗАХИРАЛ В.БАТЧИМЭГ ТАНАА

2026.04.10 № 06/1033  
танай \_\_\_\_\_-ны № \_\_\_\_\_-т

### Хязгаарлалтай дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, 8.4 Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Тогтвортой аялал жуулчлалыг хөгжүүлэх төслийн 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Бидний үзэж байгаагаар Хязгаарлалтай Санал Дүгнэлтийн Үндэслэл хэсэгт тайлбарласан зүйлсийн үр нөлөөг эс тооцвол дүгнэлтээр, санхүүгийн тайлангууд нь 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн санхүүгийн байдал болон тайлант жилийн эцсээрх, санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээ, төсвийн гүйцэтгэлийг бүх материаллаг талаар нь Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандартын дагуу үнэн зөв толилуулсан байна.

### Хязгаарлалтай санал дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторовын баталсан журам, зааврын дагуу хараат бусаар гүйцэтгэж, аудиторовын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Санхүүгийн аудитаар илэрсэн дараах 9,395,964.5 мянган төгрөгийн зөрчлүүд нь бидний тогтоосон материаллаг байдлын түвшин 14,771.6 мянган төгрөгөөс давсан бөгөөд дангаар буюу нийт дүнгээрээ санхүүгийн тайланд материаллаг нөлөөтэй боловч өргөн тархаагүй байна. Тухайлбал:

- Төсөлд гэрээгээр ажилласан гаднын хяналтын инженер, хуулийн зөвлөх, түрээсийн жолооч нарт төслийн үйл ажиллагааны зардлаас олгосон 12,692.2 мянган төгрөгийн томилолтын зардал олгож, анхан шатны баримтын бүрдэл дутуу санхүүгийн тайланд тайлагнасан,
- Тайлант онд 44,491.6 мянган төгрөгийн зөвлөх үйлчилгээний ажлын хөлсийг цахим төлбөрийн баримтаар баталгаажуулаагүй, зардлаар бүртгэсэн,
- Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газрын 2025 оны 05 дугаар сарын 22-ны өдрийн 253 дугаар тогтоолоор MON-3787/3788 төслийн хүрээнд бий болсон нийт 9,338,780.7 мянган төгрөгийн өртөг бүхий 19 ширхэг үндсэн хөрөнгийг Хэнтий, Хөвсгөл аймгийн орон нутгийн өмчид шилжүүлсэн ба төслийн бүртгэлээс хасах бүртгэл хийгээгүй байна.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1, 5.1.4, 13 дугаар зүйлийн 13.7, Сангийн сайдын 2017 оны 347 дугаар тушаалын 1 дүгээр хавсралтын 6.5 дахь "Төлбөрийн баримт нь бараа, ажил, үйлчилгээний төлбөр, тооцоо хийгдсэнийг нотлох анхан шатны цаасан болон цахим баримт" болно гэж заасныг тус тус зөрчсөн бөгөөд санхүүгийн тайлангийн нийцсэн бөгөөд зохистой байх гэсэн батламж мэдэгдлийг хангахгүй.

### **Асуудлыг онцлон тэмдэглэсэн хэсэг**

Тайлант онд МОН-3787/3788 төслийн хүрээнд бий болсон 7,626,857.7 мянган төгрөгийн барилга байгууламж, 1,274,000.0 мянган төгрөгийн тээврийн хэрэгсэл, 437,923.0 мянган төгрөгийн тоног төхөөрөмж, нийт 9,338,780.7 мянган төгрөгийн үнэ бүхий үндсэн хөрөнгийг Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газрын 2025 оны 05 дугаар сарын 22-ны өдрийн 253 дугаар тогтоолоор Хэнтий аймгийн Дадал сум, Хөвсгөл аймгийн Ханх сум, Хатгал тосгоны өмчид шилжүүлжээ.

Тус төсөл нь 2025 онд Байгаль орчин уур амьсгалын өөрчлөлтийн яамнаас Соёл, спорт аялал жуулчлал, залуучуудын яам руу шилжсэн байна.

### **Аудитын гол асуудал**

Аудитын гол асуудал гэдэг нь тайлант үеийн санхүүгийн тайлангийн аудитад хамгийн чухал нөлөөтэй хэмээн мэргэжлийн шүүн тунгаалтаар бидний авч үзсэн асуудал байна. Гол асуудлыг санхүүгийн тайлангийн аудитын хүрээнд бүхэлд нь харгалзаж, аудитын санал дүгнэлтээ илэрхийлэхэд авч үзсэн бөгөөд энэхүү гол асуудлын талаар бид тусад нь дүгнэлт гаргахгүй.

Тогтвортой аялал жуулчлалыг хөгжүүлэх төсөл нь тайлант онд Азийн Хөгжлийн Банкны шууд санхүүжилтээр 9,527,179.4 мянган төгрөг, мөнгөн орлогоор 2,063,133.0 мянган төгрөг нийт 11,590,312.4 мянган төгрөгийн санхүүжилт авч, хөрөнгө оруулалтын зардалд 9,661,367.7 мянган төгрөг, зөвлөх үйлчилгээний зардалд 751,922.4 мянган төгрөг, төслийн үйл ажиллагааны зардалд 696,381.2 мянган төгрөгийг тус тус зарцуулсан байна.

### **Бусад асуудал**

Төрийн аудитын байгууллага нь төсөвт байгууллага, төсөл хөтөлбөрийн санхүүгийн тайлангийн аудит хийхдээ Аудитын дээд байгууллагуудын олон улсын стандартыг мөрдөж ажиллах үүрэг хүлээнэ.

Санхүүгийн тайланд өгсөн бидний дүгнэлт бусад мэдээллийг хамраагүй болно.

### **Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага**

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

## Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

САНХҮҮГИЙН АУДИТЫН ГАЗРЫН  
ЗАХИРАЛ, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



*Ц. Наранчимэг* Ц.НАРАНЧИМЭГ

Тогтвортой аялал жуулчлалыг хөгжүүлэх төслийн 2025 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

**2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ**

**2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан**

2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусгавар болгосон тайлан

*/төгрөгөөр/*

Код	Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
<b>1</b>	<b>ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН</b>	<b>36,938,550,116.26</b>	<b>1,188,154,873.74</b>
<b>31</b>	<b>МӨНГӨН ХӨРӨНГӨ</b>	<b>692,649,823.99</b>	<b>1,185,269,196.37</b>
31200	Банканд байгаа бэлэн мөнгө	692,649,823.99	1,185,269,196.37
31210	Төгрөг	349,097,613.96	226,642,270.90
31211	Төрийн сангийн харилцах	349,097,613.96	226,642,270.90
31220	Гадаад валют	343,552,210.03	958,626,925.47
<b>33</b>	<b>АВЛАГА</b>	<b>154,000.00</b>	-
33100	Ажиллагчидтай холбогдсон авлага	154,000.00	-
<b>34</b>	<b>УРЬДЧИЛГАА</b>	<b>2,332,808.35</b>	<b>2,355,677.37</b>
34600	Урьдчилж гарсан зардал	2,332,808.35	2,355,677.37
<b>35</b>	<b>БАРАА МАТЕРИАЛ</b>	<b>2,105,194.54</b>	<b>530,000.00</b>
35400	Хангамжийн материал	2,105,194.54	530,000.00
35410	Бичиг хэргийн материал	97,500.00	-
35440	Түлш, шатах тослох материал	2,007,694.54	-
35470	Бусад хангамжийн материал	-	530,000.00
<b>360</b>	<b>БУСАД ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГӨ</b>	<b>36,241,308,289.38</b>	-
36800	Бусад эргэлтийн хөрөнгө	36,241,308,289.38	-
<b>2</b>	<b>ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН</b>	<b>100,948,664.18</b>	<b>49,367,647,481.79</b>
39	<b>ҮНДСЭН ХӨРӨНГӨ</b>	100,948,664.18	49,367,647,481.79
39200	Биет хөрөнгө	100,948,664.18	49,367,647,481.79
39203	Авто-тээврийн хэрэгсэл	177,500,000.00	177,500,000.00
39204	Хуримтлагдсан элэгдэл	(79,875,000.18)	(97,625,000.22)
39205	Машин тоног төхөөрөмж (компьютер)	36,193,040.00	36,523,040.00
39206	Хуримтлагдсан элэгдэл	(34,437,375.82)	(36,103,940.00)
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	20,884,000.00	20,884,000.00
39208	Хуримтлагдсан элэгдэл	(19,315,999.82)	(19,744,000.00)
39216	Дуусаагүй барилга, байгууламж	-	49,286,213,382.01
39301	Программ хангамж	6,801,650.00	6,801,650.00
39302	Хуримтлагдсан элэгдэл	(6,801,650.00)	(6,801,650.00)
<b>3</b>	<b>НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН 3=1+2</b>	<b>37,039,498,780.44</b>	<b>50,555,802,355.53</b>
<b>4</b>	<b>НИЙТ ӨР ТӨЛБӨР</b>	<b>154,000.00</b>	<b>3,390,550,167.11</b>
41300	Өглөг	154,000.00	3,390,550,167.11
41310	Ажилчидтай холбогдсон өглөг	154,000.00	2,870,322.95
41361	Байгууллагад төлөх өглөг	-	3,387,679,844.16
<b>5</b>	<b>ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН</b>	<b>37,039,344,780.44</b>	<b>47,165,252,188.42</b>
<b>51</b>	<b>Засгийн газрын хувь оролцоо</b>	<b>37,039,344,780.44</b>	<b>47,165,252,188.42</b>
51200	Хуримтлагдсан үр дүн	37,039,344,780.44	47,165,252,188.42
51210	Өмнөх үеийн үр дүн	28,905,954,379.06	37,039,344,780.44
51220	Тайлант үеийн үр дүн	8,133,390,401.38	10,125,907,407.98
<b>6</b>	<b>ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН 6=4+5</b>	<b>37,039,498,780.44</b>	<b>50,555,802,355.53</b>

Тогтвортой аялал жуулчлалыг хөгжүүлэх төслийн 2025 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

**2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан**

2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусгавар болгосон тайлан

*/төгрөгөөр/*

код	Үзүүлэлт	Өмнөх он	Тайлант он
<b>I</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН</b>	<b>10,787,127,260.79</b>	<b>11,591,092,124.62</b>
<b>12</b>	<b>ТАТВАРЫН БУС ОРЛОГО</b>	<b>10,787,127,260.79</b>	<b>11,591,092,124.62</b>
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	10,783,739,578.79	11,590,312,469.07
1200044	Гадаадын эх үүсвэрээс санхүүжих	10,783,739,578.79	11,590,312,469.07
120009	Бусад орлого	2,711,550.00	-
120018	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого - Бараа материал	676,132.00	779,655.55
<b>II</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН</b>	<b>2,667,557,737.72</b>	<b>1,478,308,621.32</b>
<b>21</b>	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	<b>2,667,557,737.72</b>	<b>1,478,308,621.32</b>
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	2,667,557,737.72	1,478,308,621.32
<b>2101</b>	<b>Цалин хөлс болон нэмэгдэл урамшил</b>	<b>404,150,307.00</b>	<b>375,835,984.66</b>
210101	Үндсэн цалин	404,150,307.00	375,835,984.66
<b>2102</b>	<b>Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл</b>	<b>47,138,048.38</b>	<b>43,560,571.27</b>
210201	Тэтгэврийн даатгалын зардал	31,740,386.09	29,343,279.66
210202	Тэтгэмжийн даатгалын зардал	4,041,503.07	3,815,512.90
210203	ҮОМШӨ-ний даатгалын зардал	2,020,751.54	1,937,256.46
210204	Ажилгүйдлийн даатгалын зардал	1,867,081.54	1,590,376.46
210205	Эрүүл мэндийн даатгалын зардал	7,468,326.14	6,874,145.79
<b>2103</b>	<b>Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал</b>	<b>81,244,717.57</b>	<b>88,016,054.81</b>
210304	Байрны түрээс	81,244,717.57	88,016,054.81
<b>2104</b>	<b>Хангамж, бараа материалын зардал</b>	<b>8,849,020.13</b>	<b>8,576,017.00</b>
210401	Бичиг хэрэг	2,600,200.00	4,072,100.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	5,879,806.13	4,266,104.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	369,014.00	237,813.00
<b>2106</b>	<b>Эд хогшил, урсгал засварын зардал</b>	<b>8,556,600.00</b>	<b>17,132,326.80</b>
210601	Багаж, техник, хэрэгсэл	4,036,000.00	2,800,000.00
210604	Урсгал засвар	4,520,600.00	14,332,326.80
<b>2107</b>	<b>Томилолт, зочны зардал</b>	<b>84,966,097.00</b>	<b>128,897,867.09</b>
210702	Дотоод албан томилолт	84,966,097.00	128,897,867.09
<b>2108</b>	<b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж</b>	<b>1,428,155,060.07</b>	<b>795,299,535.29</b>
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	1,390,899,720.42	757,507,280.81
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	33,000,000.00	33,000,000.00

**Тогтвортой аялал жуулчлалыг хөгжүүлэх төслийн 2025 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан**

210803	Даатгалын үйлчилгээ	4,081,291.65	4,015,434.98
210804	Тээврийн хэрэгслийн татвар	174,048.00	598,644.00
210808	Банк, санхүүгийн байгууллагын үйлчилгээний хураамж	-	178,175.50
<b>2109</b>	<b>Бараа үйлчилгээний бусад зардал</b>	<b>604,497,887.57</b>	<b>20,990,264.40</b>
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	574,437,155.00	1,145,700.00
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	30,060,732.57	19,844,564.40
<b>III</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (III)=(I)-(II)</b>	<b>8,119,569,523.07</b>	<b>10,112,783,503.30</b>
<b>IV</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ОРЛОГЫН ДҮН</b>	<b>13,820,878.31</b>	<b>13,123,904.68</b>
145001	Гадаад валютын ханшийн зөрүүний олз	13,820,878.31	13,123,904.68
VII	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ҮР ДҮН (VII)=(IV)-(V)	13,820,878.31	13,123,904.68
<b>VI</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ НИЙТ ҮР ДҮН (VI)=(III)+(VII)</b>	<b>8,133,390,401.38</b>	<b>10,125,907,407.98</b>

**2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан**

2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусгавар болгосон тайлан

*/төгрөгөөр/*

код	Үзүүлэлт	Өмнөх он	Тайлант он
<b>I</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН</b>	<b>2,195,486,088.33</b>	<b>-</b>
1200044	Гадаадын эх үүсвэрээс санхүүжих	2,187,979,538.33	-
120009	Бусад орлого	7,506,550.00	-
<b>II</b>	<b>НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН</b>	<b>1,413,371,746.50</b>	<b>1,228,487,463.80</b>
21	УРСГАЛ ЗАРДАЛ	1,413,371,746.50	1,228,487,463.80
<b>2101</b>	<b>Цалин хөлс болон нэмэгдэл урамшил</b>	<b>404,150,307.00</b>	<b>372,965,661.71</b>
210101	Үндсэн цалин	404,150,307.00	372,965,661.71
<b>2102</b>	<b>Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл</b>	<b>47,138,048.38</b>	<b>43,560,571.27</b>
210201	Тэтгэврийн даатгалын зардал	31,740,386.09	30,612,329.66
210202	Тэтгэмжийн даатгалын зардал	4,041,503.07	3,420,072.90
210203	ҮОМШӨ-ний даатгалын зардал	2,020,751.54	1,710,036.46
210204	Ажилгүйдлийн даатгалын зардал	1,867,081.54	1,563,626.46
210205	Эрүүл мэндийн даатгалын зардал	7,468,326.14	6,254,505.79
<b>2103</b>	<b>Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал</b>	<b>81,244,717.57</b>	<b>88,016,054.81</b>
210301	Гэрэл, цахилгаан	-	3,146,335.18
210304	Байрны түрээс	81,244,717.57	84,869,719.63
<b>2104</b>	<b>Хангамж, бараа материалын зардал</b>	<b>8,810,420.13</b>	<b>8,228,517.00</b>
210401	Бичиг хэрэг	2,561,600.00	3,724,600.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	5,879,806.13	4,266,104.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	369,014.00	237,813.00
<b>2106</b>	<b>Эд хогшил, урсгал засварын зардал</b>	<b>8,556,600.00</b>	<b>17,686,000.00</b>
210601	Багаж, техник, хэрэгсэл	4,036,000.00	3,580,000.00
210604	Урсгал засвар	4,520,600.00	14,106,000.00
<b>2107</b>	<b>Томилолт, зочны зардал</b>	<b>83,394,320.00</b>	<b>121,968,100.00</b>
210702	Дотоод албан томилолт	83,394,320.00	121,968,100.00
<b>2108</b>	<b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж</b>	<b>780,077,333.42</b>	<b>574,916,859.01</b>
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	742,904,185.42	537,279,911.01

**Тогтвортой аялал жуулчлалыг хөгжүүлэх төслийн 2025 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан**

210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	33,000,000.00	33,000,000.00
210803	Даатгалын үйлчилгээ	3,999,100.00	4,038,304.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	174,048.00	598,644.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	-	1,145,700.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	-	1,145,700.00
<b>III</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (III)=(I)-(II)</b>	<b>782,114,341.83</b>	<b>(1,228,487,463.80)</b>
<b>V</b>	<b>ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН</b>	<b>975,658,219.45</b>	<b>355,150,121.00</b>
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	975,658,219.45	355,150,121.00
2200	Дотоод эх үүсвэрээр	975,658,219.45	355,150,121.00
220001	Барилга байгууламж	974,233,219.45	354,820,121.00
225106	Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал	1,425,000.00	330,000.00
<b>VI</b>	<b>ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VI)=(IV)-(V)</b>	<b>(975,658,219.45)</b>	<b>(355,150,121.00)</b>
<b>14</b>	<b>Бусад эх үүсвэр</b>	<b>13,820,878.31</b>	<b>2,076,256,957.18</b>
<b>145001</b>	<b>Гадаад валютын ханшийн зөрүүний олз</b>	<b>13,820,878.31</b>	<b>13,123,904.68</b>
145102	Бусад засгийн газрын гадаад төслийн зээл шинээр авах	-	2,063,133,052.50
<b>VII</b>	<b>САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭНИЙ ДҮН</b>	<b>13,820,878.31</b>	<b>2,076,256,957.18</b>
<b>VIII</b>	<b>НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VIII)=(III)+(VI)+(VII)</b>	<b>(179,722,999.31)</b>	<b>492,619,372.38</b>
101	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	872,372,823.30	692,649,823.99
20	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	692,649,823.99	1,185,269,196.37

**2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан**

2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусгавар болгосон тайлан

/төгрөгөөр/

код	Үзүүлэлт	Хуримтлагдсан үр дүн	Засгийн газрын хувь оролцооны нийт дүн
<b>1</b>	<b>2023 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл</b>	<b>28,905,954,379.06</b>	<b>28,905,954,379.06</b>
3	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	28,905,954,379.06	28,905,954,379.06
4	Тайлант үеийн үр дүн	8,133,390,401.38	8,133,390,401.38
<b>5</b>	<b>2024 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл</b>	<b>37,039,344,780.44</b>	<b>37,039,344,780.44</b>
6	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	37,039,344,780.44	37,039,344,780.44
7	Тайлант үеийн үр дүн	10,125,907,407.98	10,125,907,407.98
<b>8</b>	<b>2025 оны 12-р сарын 31-наарх үлдэгдэл</b>	<b>47,165,252,188.42</b>	<b>47,165,252,188.42</b>

**2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан**

2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусгавар болгосон тайлан

/төгрөгөөр/

код	Үзүүлэлт	Төлөвлөгөө	Гүйцэтгэл
<b>II</b>	<b>НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН</b>	<b>11,217,938,500.00</b>	<b>11,109,671,301.37</b>
<b>21</b>	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	<b>1,464,938,500.00</b>	<b>1,448,303,635.90</b>
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	1,464,938,500.00	1,448,303,635.90
<b>2101</b>	<b>Цалин хөлс болон нэмэгдэл урамшил</b>	<b>375,700,000.00</b>	<b>372,965,661.71</b>
210101	Үндсэн цалин	375,700,000.00	372,965,661.71
<b>2102</b>	<b>Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл</b>	<b>46,962,500.00</b>	<b>43,560,571.27</b>

**Тогтвортой аялал жуулчлалыг хөгжүүлэх төслийн 2025 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан**

210201	Тэтгэврийн даатгал	31,934,500.00	30,612,329.66
210202	Тэтгэмжийн даатгал	3,757,000.00	3,420,072.90
210203	ҮОМШӨ-ний даатгал	1,878,500.00	1,710,036.46
210204	Ажилгүйдлийн даатгал	1,878,500.00	1,563,626.46
210205	Эрүүл мэндийн даатгал	7,514,000.00	6,254,505.79
<b>2103</b>	<b>Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал</b>	<b>90,100,000.00</b>	<b>88,016,054.81</b>
210301	Гэрэл, цахилгаан	3,400,000.00	3,146,335.18
210304	Байрны түрээс	86,700,000.00	84,869,719.63
<b>2104</b>	<b>Хангамж, бараа материалын зардал</b>	<b>9,300,000.00</b>	<b>8,228,517.00</b>
210401	Бичиг хэрэг	4,000,000.00	3,724,600.00
210402	Тээвэр, шатахуун	700,000.00	-
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	4,300,000.00	4,266,104.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	300,000.00	237,813.00
<b>2106</b>	<b>Эд хогшил, урсгал засварын зардал</b>	<b>18,151,000.00</b>	<b>18,016,000.00</b>
210601	Багаж, техник, хэрэгсэл	3,580,000.00	3,580,000.00
210604	Урсгал засвар	14,571,000.00	14,436,000.00
<b>2107</b>	<b>Томилолт, зочны зардал</b>	<b>122,000,000.00</b>	<b>121,968,100.00</b>
210702	Дотоод албан томилолт	122,000,000.00	121,968,100.00
<b>2108</b>	<b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж</b>	<b>802,725,000.00</b>	<b>795,548,731.11</b>
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	763,000,000.00	757,911,783.11
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	33,000,000.00	33,000,000.00
210803	Даатгалын үйлчилгээ	4,500,000.00	4,038,304.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	600,000.00	598,644.00
210805	Тээврийн хэрэгслийн оношилгоо	25,000.00	-
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	1,600,000.00	-
<b>22</b>	<b>ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ</b>	<b>9,753,000,000.00</b>	<b>9,661,367,665.47</b>
220001	Барилга байгууламж	9,667,000,000.00	9,661,367,665.47
222001	Тоног төхөөрөмж	86,000,000.00	-
<b>8</b>	<b>ТЭНЦВЭРЖҮҮЛСЭН НИЙТ ТЭНЦЭЛ</b>	<b>(11,217,938,500.00)</b>	<b>(11,109,671,301.37)</b>
9	АЛДАГДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	11,217,938,500.00	11,109,671,301.37
7	Харилцах болон хадгаламжийн дансны цэвэр өөрчлөлт	-	(480,641,167.70)
<b>72</b>	<b>Засгийн газрын зээл</b>	<b>11,217,938,500.00</b>	<b>11,590,312,469.07</b>
722	Гадаад	11,217,938,500.00	11,590,312,469.07
7221	Төслийн зээл	11,217,938,500.00	11,590,312,469.07
322101	Шинээр авах	11,217,938,500.00	11,590,312,469.07
4	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	-	704,628,028.67
5	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	-	1,185,269,196.37
<b>62</b>	<b>АЖИЛЛАГСАДЫН ТОО</b>	<b>12</b>	<b>12</b>
620001	Удирдах ажилтан	2	2
620002	Гүйцэтгэх ажилтан	9	9
620003	Үйлчлэх ажилтан	1	1

### 3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА

#### 3.1 Төслийн үйл ажиллагаа

Монгол улсын Засгийн газар болон Азийн хөгжлийн банкны хооронд байгуулсан санхүүжилтийн ерөнхий хэлэлцээрийн дагуу Соёл, спорт аялал жуулчлал, залуучуудын яамны харъяа Тогтвортой аялал жуулчлалыг хөгжүүлэх төсөл нь Тусгай хамгаалалтай газар нутагт тогтвортой аялал жуулчлал хөгжүүлэх үндэсний загварыг бий болгох, төсөл хэрэгжиж буй орон нутгийн байгаль хамгаалал, аялал жуулчлал, эдийн засгийн асуудлыг цогцоор шийдвэрлэхэд дэмжлэг үзүүлэх зорилготой хэрэгжиж байна. Үүнд:

Зорилт 1: Нутгийн оршин суугчдад түшиглэсэн хүртээмжтэй аялал жуулчлалын төлөвлөлт болон чадавхыг сайжруулах,

Зорилт 2: Аялал жуулчлалыг дэмжих дэд бүтцийг байгуулах,

Зорилт 3: Хог хаягдлын менежментийг сайжруулах,

Зорилт 4: Тусгай хамгаалалттай газрын менежментийг боловсронгуй болгох зорилтыг тус тус тодорхойлсон.

Тус төсөл нь 2019 оны 8 дугаар сарын 06-ны өдрөөс 2026 оны 6 дугаар сарын 30-ны өдрийг хүртэлх хугацаанд Азийн Хөгжлийн банкны 38,000.0 мянган ам.долларын санхүүжилт, Монгол улсын Засгийн газрын 4,000.0 мянган ам.долларын татвараас чөлөөлөх замаар санхүүжүүлэхээр баталсан байна.

#### 3.2 Төсөл хэрэгжүүлэх нэгжийн гадаад, дотоод орчин

Төсөл хэрэгжүүлэгч нэгж нь Сангийн сайдын 2021 оны 01 дүгээр сарын 11-ний өдрийн 4 дүгээр тушаалаар баталсан “Засгийн газрын гадаад зээлийн хөрөнгийг ашиглах, эдгээр хөрөнгөөр санхүүжих төсөл, арга хэмжээг хэрэгжүүлэх, зохион байгуулах, санхүүжүүлэх, хяналт тавих, үнэлэх журам”-ыг мөрдөж ажилладаг.

Тогтвортой аялал жуулчлалыг хөгжүүлэх төсөл нь Төсвийн тухай хууль, Төлбөр тооцоог үндэсний мөнгөн тэмдэгтээр хийх тухай хууль, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хууль, Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил үйлчилгээ худалдан авах тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Шилэн дансны тухай хуулиудыг үйл ажиллагаандаа мөрдөн ажиллаж байна.

Тайлант хугацаанд төслийн үйл ажиллагаа, санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрддөг дараах хууль, тогтоомж бодлого чиглэлд өөрчлөлт орсон байна. Үүнд:

- Төсвийн тухай хууль
- Сангийн сайдын 2025 оны 01 дүгээр сарын 03-ны өдрийн А/3 дугаар тушаалаар батлагдсан "Төсвийн байгууллагын дагаж мөрдөх нягтлан бодох бүртгэлийн журам"
- Сангийн сайдын 2025 оны 10 дугаар сарын 01-ны өдрийн 174 тоот “Нэгдсэн төсөл хэрэгжүүлэх нэгжид шилжихэд мөрдөх түр журам” зэрэг болно.

Төслийн удирдлагын хэрэгжүүлж буй дотоод хяналтуудаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилтийг үр нөлөөтэй гэж үнэллээ.

Тогтвортой аялал жуулчлалыг хөгжүүлэх төслийн 2025 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

Дотоод аудитын чиг үүрэг, түүний гүйцэтгэсэн ажлын талаар ойлголт олж авснаар дотоод аудиторын гүйцэтгэсэн ажлыг аудитад ашиглах шаардлагагүй гэж үзлээ.

### 3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Тогтвортой аялал жуулчлалыг хөгжүүлэх төслийн 2025 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккруэл сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн байна.

Төслийн мөрдөж буй Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь үйл ажиллагааны онцлог, холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандарттай нийцсэн байна.

### 3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлтүүд

Тогтвортой аялал жуулчлалыг хөгжүүлэх төслийн 2025 оны санхүүгийн тайланг Сангийн сайдын 2025 оны А/3 дугаар тушаалаар баталсан “Төсвийн байгууллагын дагаж мөрдөх нягтлан бодох бүртгэлийн журам”-ын дагуу бэлтгэсэн байна.

Тайлант хугацаанд нягтлан бодох бүртгэлийн бодлогод өөрчлөлт ороогүй байна.

Тайлант оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 13,516,303.5 мянган төгрөгөөр буюу 36.5 хувиар өссөн байна.

#### Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
А	1	2	3=2-1
Мөнгөн хөрөнгө	692,649.8	1,185,269.2	492,619.4
Авлага	154.0	-	(154.0)
Урьдчилж гарсан зардал	2,332.8	2,355.6	22.8
Бараа материал	2,105.2	530.0	(1,575.2)
Бусад эргэлтийн бус хөрөнгө	36,241,308.3	-	(36,241,308.3)
Үндсэн хөрөнгө	100,948.7	81,434.1	(19,514.6)
Дуусаагүй барилга		49,286,213.4	49,286,213.4
<b>Нийт хөрөнгө</b>	<b>37,039,498.8</b>	<b>50,555,802.3</b>	<b>13,516,303.5</b>
Өр төлбөр	154.0	3,390,550.2	3,390,396.2
Хуримтлагдсан үр дүн	37,039,344.8	47,165,252.1	10,125,907.3
<b>Өр төлбөр ба цэвэр хөрөнгө/өмчийн дүн</b>	<b>37,039,498.8</b>	<b>50,555,802.3</b>	<b>13,516,303.5</b>

Дээрх хүснэгтээс харахад дараах дансанд нөлөө бүхий өөрчлөлт гарсан байна.

Үүнд:

- Мөнгөн хөрөнгө дансны үлдэгдэл 1,185,269.2 мянган төгрөг болж, 492,619.4 мянган төгрөгөөр нэмэгдсэн нь Азийн хөгжлийн банкны зээлийн эх үүсвэрээс 2,063,133.0 мянган төгрөгийн санхүүжилт хийгдэж, 13,123.9 мянган төгрөгийн валютын ханшийн зөрүүний олзыг бүртгэж, гэрээт барилгын ажлын санхүүжилтэд 354,820.1 мянган төгрөг, зөвлөх үйлчилгээний ажлын хөлсөнд 531,112.4 мянган төгрөг, үйл ажиллагааны зардалд 697,705.0 мянган төгрөг тус тус зарцуулснаас,

## Тогтвортой аялал жуулчлалыг хөгжүүлэх төслийн 2025 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

- Авлага дансны үлдэгдэл 154.0 мянган төгрөгөөр буурсан нь өмнөх оны ХХОАТ-ын авлагыг барагдуулснаас,
- Урьдчилж гарсан дансны үлдэгдэл 2,355.6 мянган төгрөг болж 22.8 мянган төгрөгөөр өссөн нь тайлант онд даатгалын байгууллагад шилжүүлсэн 4,038.3 мянган төгрөгөөр нэмэгдэж, 4,015.5 мянган төгрөгийн даатгалын зардал бүртгэснээр буурсан,
- Бараа материал дансны үлдэгдэл 530.0 мянган төгрөг болж 1,575.2 мянган төгрөгөөр буурсан нь төслийн хөрөнгөөр 26,719.9 мянган төгрөгийн бараа материалыг худалдан авч, 779.7 мянган төгрөгийн шатахууны урамшууллыг үнэ төлбөргүй орлогоор бүртгэж авсан бөгөөд, үйл ажиллагаанд 29,074.8 мянган төгрөгийн бараа материалыг зарцуулснаас,
- Бусад эргэлтийн хөрөнгө дансны үлдэгдэл 36,241.3 мянган төгрөгөөр буурсан нь дуусаагүй барилга байгууламжийн дансанд шилжүүлэн бүртгэснээс,
- Үндсэн хөрөнгө дансны үлдэгдэл 81,434.1 мянган төгрөг болж 19,514.6 мянган төгрөгөөр буурсан нь төсвийн хөрөнгөөр 330.0 мянган төгрөгийн цаг бүртгэлийн төхөөрөмж худалдан авч, 19,844.6 мянган төгрөгийн элэгдлийн зардал тооцсоноос,
- Дуусаагүй барилга байгууламж дансны үлдэгдэл 49,286.2 мянган төгрөг болж өссөн нь бусад эргэлтийн хөрөнгө данснаас 36,241.3 мянган төгрөгийг шилжүүлэн бүртгэсэн бол тайлант онд 13,044.9 мянган төгрөгийн барилгын ажлын өртгийг нэмж бүртгэснээс,
- Өр төлбөр дансны үлдэгдэл 3,390,396.2 мянган төгрөгөөр өссөн нь ХХОАТ-ын 154.0 мянган төгрөгийг төлж, гэрээт ажлын 3 компанийн гүйцэтгэлийн төлбөр 3,383,537.5 мянган төгрөгийн, Засгийн газрын авто бааз ТӨААТҮГ-н машин түрээсийн төлбөр 4,142.4 мянган төгрөгийн, цалингийн өглөг 2,870.3 мянган төгрөгийн өглөгөөр тус тус нэмж бүртгэснээс шалтгаалсан байна.

### 3.5 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

#### 3.5.1 Төсвийн төлөвлөлт

Тогтвортой аялал жуулчлалыг хөгжүүлэх төсөл нь 2025 оны төсвийн төсөлд зардлыг санхүүжүүлэх эх үүсвэрийг гадаадын зээл тусламжийн 55,491,087.6 мянган төгрөгөөр бүрдүүлж, урсгал зардалд 1,051,476,3 мянган төгрөгийг, зөвлөх үйлчилгээний зардалд 3,035,597.9 мянган төгрөгийг, хөрөнгийн зардалд 51,404,013.4 мянган төгрөгийг тус тус зарцуулахаар батлуулсан байна.

#### 3.5.2 Төсвийн гүйцэтгэл

Тайлант онд төсөв захирагчийн хөтөлбөр, арга хэмжээг гадаадын зээл, тусламжийн 11,590,312.4 мянган төгрөгийн санхүүжилт авч, хөрөнгө оруулалтын зардалд 9,661,367.7 мянган төгрөг, зөвлөх үйлчилгээний зардалд 751,922.4 мянган төгрөг, төслийн нэгжийн зардалд 696,381.2 мянган төгрөг зэрэг нийт зардал 11,109,671.3 мянган төгрөг тус тус зарцуулсан нь 99.0 хувийн гүйцэтгэлтэй ажилласан байна.

**Тогтвортой аялал жуулчлалыг хөгжүүлэх төслийн 2025 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан**

**Хүснэгт 2. Хөтөлбөр, арга хэмжээний төлөвлөгөө, гүйцэтгэл**

*/мянган төгрөгөөр/*

д/д	Хөтөлбөр, арга хэмжээ	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Биелэлт /хувь/
70207	Хөрөнгө оруулалтын зардал	9,753,000.0	9,661,367.7	91,632.3	99.1
80104	Гадаад тусламжаар хэрэгжүүлэх зөвлөх үйлчилгээний зардал	763,000.0	751,922.4	11,077.6	98.5
80105	Гадаад тусламжаар хэрэгжүүлэх төсөл хэрэгжүүлэх нэгжийн зардал	701,938.5	696,381.2	5,557.3	99.2
	<b>ДҮН</b>	<b>11,217,938.5</b>	<b>11,109,671.3</b>	<b>108,267.2</b>	<b>99.0</b>

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.5-д харуулав.

Монгол Улсын Ерөнхий аудитораас баталсан “Төрийн аудитын байгууллагын 2025-2026 онд гүйцэтгэх аудитын ерөнхий чиглэл”-ийн хүрээнд тус байгууллагаас авсан судалгаанд дүн шинжилгээ хийхэд дараах байдалтай байна.

- Тус төсөл нь тайлант онд 12 ажиллагсадтай байхаар орон тоо баталснаас гүйцэтгэлээр 12 ажиллагсадтай үйл ажиллагаа явуулсан.
- Төрд учирсан хохиролыг барагдуулахтай холбоотой зардал гараагүй байна.
- Гадаад томилолтоор ажиллаагүй, хэвлэл мэдээллийн байгууллагаар гүйцэтгүүлэх гэрээт ажил хийгдээгүй.

**3.5.3 Төсөл хөтөлбөрийн үе шат, хүрэх үр дүн**

Тус төсөл хэрэгжих хугацаанд нийт 4 хөтөлбөрийн 39 арга хэмжээг хэрэгжүүлэхээр төлөвлөсөн байна.

д/д	Хөтөлбөр	Хэрэгжилтийн явц /хувиар/
1	<b>Зорилт1.</b> Нутгийн оршин суугчдад түшиглэсэн хүртээмжтэй аялал жуулчлалын төлөвлөлт болон чадавхыг сайжруулах	72.5
2	<b>Зорилт2.</b> Аялал жуулчлалыг дэмжих дэд бүтцийг байгуулах	77.5
3	<b>Зорилт3.</b> Хог хаягдлын менежментийг сайжруулах	60.0
4	<b>Зорилт4.</b> ТХГ-ын менежментийг боловсронгуй болгох	63.0
	<b>Нийт хэрэгжилтийн дүн</b>	<b>68.3</b>

**Хүснэгт 3. Төсөл хөтөлбөрийн арга хэмжээний хүрэх үр дүн, биелэлт**

*/мянган төгрөгөөр/*

№	Дэд зорилт	Ажил	Ажлын төрөл	Ажлын нэр	Гэрээний дүн	Нийт гарсан санхүүжилт	Гэрээний хэрэгжилтийн хувь
1	1.1.2	Дадал сумын аялал жуулчлалын төлөвлөгөө боловсруулж, батлуулах	Зөвлөх үйлчилгээ	Эко-аялал жуулчлалын төлөвлөлтийн зөвлөх үйлчилгээ	708,055.0	708,055.0	100.0%
	1.1.4	ХНБЦГ, ОББЦГ дах аялал жуулчлалын сайн дурын эко-магадлан итгэмжлэлийн хөтөлбөрийг боловсруулж, нэвтрүүлэх					
	1.2.2	ХНБЦГ, ОББЦГ-ын аялал жуулчлалын зөвлөлийг байгуулах					

**Тогтвортой аялал жуулчлалыг хөгжүүлэх төслийн 2025 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан**

	<b>1.3.1</b>	ЧХАЖЦ-ын менежментийн байгууллагыг байгуулахад дэмжлэг үзүүлэх				
	<b>1.3.2</b>	Орон нутгийн иргэдийн өрсөлдөх чадвар, аялал жуулчлалын салбарт ажиллах чадавхыг нэмэгдүүлэх				
	<b>1.3.3</b>	Орон нутгийн иргэдийн өрсөлдөх чадвар, аялал жуулчлалын салбарт ажиллах чадавхыг нэмэгдүүлэх				
	<b>1.3.4</b>	Зээлийн эргэлтийн сан				
	<b>4.3</b>	ХУТХГ-ын нийтийн зориулалттай 15 км аяллын жимийн талаар зөвлөмж боловсруулах				
	<b>4.4</b>	ХНБЦГ, ОББЦГ-ын Менежментийн төлөвлөгөө боловсруулах				
		ХУТХГ, ОББЦГ-ын Хамгаалалтын захиргааны чадавхыг сайжруулах				
<b>4.5</b>	ХНБЦГ, ОББЦГ-ын аялал жуулчлалын зөвлөлийн чадавхыг бэхжүүлэх					
	Ашиглалт хариуцсан нэгжүүдийг байгууламжуудын АЗҮ-ний талаар сургалтад хамруулах					
2	<b>2.1.1</b>	Хөвсгөл аймгийн Авто замын зураг төсөл боловсруулах, хяналт хийх	Авто замын зураг төсөл болон хяналтын зөвлөх үйлчилгээ	2,981,221.3	2,348,017.4	80.0%
	<b>2.1.2</b>	Хөвсгөл аймгийн авто зогсоолын зураг төсөл боловсруулах, хяналт хийх				
	<b>2.1.4</b>	Дадал сумаас ЧХАЖЦ хүртэлх авто зам, зогсоолын зураг төсөл боловсруулах, хяналт хийх				
	<b>2.2.3</b>	ЧХАЖЦ руу татах цахилгаан дамжуулах шугамын зураг төсөл боловсруулах, хяналт хийх				
3	<b>3.1.2</b>	Хөвсгөл, Хэнтий аймгийн Ариун цэврийн байгууламжийн зураг төсөл боловсруулах, хяналт хийх	АЦБ, БУЦБ болон Хатуу хог хаягдлын байгууламжийн иж бүрэн зураг төсөл боловсруулах, барилгын ажилд хяналт тавих зөвлөх үйлчилгээ	210,800.0	200,260.0	95.0%
	<b>3.1.3</b>	Хөвсгөл, Хэнтий аймгийн Бохир ус цэвэрлэх байгууламжийн зураг төсөл боловсруулах, хяналт хийх				
	<b>3.2.1</b>	Хөвсгөл, Хэнтий аймгийн хатуу хог хаягдлын байгууламжийн зураг төсөл боловсруулах, хяналт хийх				
4	<b>1.2.1</b>	Мөрөн хотын аялал жуулчлалын талбайн зураг төсөл боловсруулах, хяналт хийх	ХУТХГ-ын Хамгаалалтын захиргааны барилга, Мөрөн	555,265.0	265,372.3	75.0%

**Тогтвортой аялал жуулчлалыг хөгжүүлэх төслийн 2025 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан**

	<b>4.1</b>	Хөвсгөл аймгийн ХУТХГ-ын Хамгаалалтын захиргаа/жуулчны мэдээллийн төвийн зураг төсөл боловсруулах, хяналт хийх		хотын жуулчны талбайн иж бүрэн зураг төсөл боловсруулах, барилгын ажилд хяналт тавих зөвлөх үйлчилгээ			
5	<b>1.1.1</b>	"Ханх сумын хөгжлийн ерөнхий төлөвлөгөө" боловсруулах компанийг сонгон шалгаруулах, төлөвлөгөөг боловсруулах, батлуулах		Ханх сумын хөгжлийн ерөнхий төлөвлөгөө боловсруулах, зөвлөх үйлчилгээ	800,500.4	800,500.4	100.0%
6	<b>2.2.1</b>	ЧХАЖЦ-ын зураг төсөл боловсруулах		ЧХАЖЦ-ын барилга байгууламжийн иж бүрэн зураг төсөл боловсруулах, зөвлөх үйлчилгээ	1,724,586.9	344,917.4	10.0%
7	<b>2.2.1</b>	ЧХАЖЦ-ын барилга угсралтын ажилд захиалагчийн хяналт хийх		Хэнтий дэд төслийн хяналтын зөвлөх үйлчилгээ	1,198,248.9	719,518.9	60.0%
9	<b>1.3.1</b>	Хэнтий, Хөвсгөл аймагт /Олон нийтийн оролцоотой худалдан авах ажиллагаа /ОНОХАА/-ны барилга угсралтын ажилд захиалагчийн хяналт хийх		Хөвсгөл дэд төслийн барилга угсралтын хяналтын зөвлөх үйлчилгээ	641,868.7	32,153.0	5.0%
	<b>3.1.2</b>	Хөвсгөл, Хэнтий аймгийн Ариун цэврийн байгууламжийн барилгын ажилд захиалагчийн хяналт хийх					
	<b>4.1</b>	Хөвсгөл аймгийн ХУТХГ-ын Хамгаалалтын захиргаа/жуулчны мэдээллийн төвийн барилгын ажилд захиалагчийн хяналт хийх					
10	<b>3.1.2</b>	Хөвсгөл, Хэнтий аймгийн Ариун цэврийн байгууламжийн барилгын ажил	Барилга, байгууламжийн гүйцэтгэл	ХУТХГ-ын Хамгаалалтын захиргаа ба жуулчны мэдээллийн төвийн барилга угсралт	8,257,041.5	3,143,041.7	64.0%
	<b>4.1</b>	Хөвсгөл аймгийн ХУТХГ-ын Хамгаалалтын захиргаа/жуулчны мэдээллийн төвийн барилгын ажил					
	<b>4.2</b>	Хөвсгөл нуурын байгалийн цогцолборт газарт Нэвтрэх төлбөр авах цэгийн барилгын ажил					
11	<b>2.1.3</b>	Хөвсгөл аймгийн Авто зам, зогсоолын барилгын ажил		Хатгалын төв замыг орон нутгийн аялал жуулчлалын замтай холбох, Хатгал-Жанхай-Тойлогт чиглэлийн авто зам, Хатгал-Хүзүүвчийн Шил	10,531.5	6,500.8	58.0%

**Тогтвортой аялал жуулчлалыг хөгжүүлэх төслийн 2025 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан**

				чиглэлийн авто зам, Хатгалын авто зогсоолын /7/ барилгын ажил			
12	2.1.3	Хөвсгөл аймгийн Авто зам, зогсоолын барилгын ажил		Хатгалын төв замыг орон нутгийн аялал жуулчлалын замтай холбох, Хатгал-Жанхай-Тойлогт чиглэлийн авто зам, Хатгал-Хүзүүвчийн Шил чиглэлийн авто зам, Хатгалын авто зогсоолын барилгын ажил	5,779.0		0%
13	3.2.1	Хөвсгөл, Хэнтий аймагт Хатуу хог хаягдлын Ландфиллын барилгын ажил, хуучин хогийн цэгийг нөхөн сэргээх, машин, тоног төхөөрөмж нийлүүлэх		Хатгал, Ханх, Дадал сумдын хатуу хог хаягдлын байгууламжийн барилга угсралт	6,760,993.2	6,396,908.4	100.0%
14	2.1.5	Дадал сумаас ЧХАЖЦ хүртэлх авто зам, зогсоолын барилгын ажил		ЧХАЖЦ-ын Зам, зогсоол, цахилгаан дамжуулах шугамын барилга угсралт	7,351,761.7	3,808,265.5	100.0%
	2.2.3	ЧХАЖЦ руу татах цахилгаан дамжуулах шугамын барилгын ажил					
15	3.1.3	Хөвсгөл аймгийн Хатгал тосгон, Ханх суманд Бохир ус цэвэрлэх байгууламжийн барилгын ажил, машин нийлүүлэх		Хатгал, Ханхын БУЦБ-ийн барилга угсралт	2,279,540.3	2,059,854.9	100.0%
16	2.2.2	ЧХАЖЦ-ын барилгын ажил		ЧХАЖЦ-ын Мэдээллийн төв, цэвэрлэх байгууламжийн зураг төсөл, барилга угсралт, бараа нийлүүлэлт	7,499.9	2,811.0	45.0%
17	1.3.1	Хэнтий аймагт /Олон нийтийн оролцоотой худалдан авах ажиллагаа /ОНОХАА/	Зөвлөхөөс бусад бусдаар гүйцэтгүүлэх ажил	"Хөрш бүл-1" дэд төсөл	120,897.6	120,897.6	100.0%
18				"Хөрш бүл-2" дэд төсөл	78,110.9	78,110.9	100.0%
19				"Яргайт отоглох цэг" дэд төсөл	53,055.0	53,055.0	100.0%
20				"Бөөр булаг" болон "Хөрш бүл-3" дэд төсөл	200,000.0	120,149.0	100.0%
21				Хог ангилан ялгах сав нийлүүлэх ажил	27,000.0	27,000.0	100.0%
22				"Дотоодын брэнд бүтээгдэхүүн үйлдвэрлэх тоног төхөөрөмж нийлүүлэх"	70,000.0	70,000.0	100.0%

**Тогтвортой аялал жуулчлалыг хөгжүүлэх төслийн 2025 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан**

23	<b>4.2</b>	ХУТХГ-ын Хамгаалалтын захиргаанд тусгай зориулалтын 2 ш завь нийлүүлэх		2ш завь худалдан авалт	223,080.0	223,080.0	100.0%
24	<b>3.2.1</b>	Хөвсгөл, Хэнтий аймагт Хатуу хог хаягдлын Ландфиллын барилгын ажил	Бараа	Хөвсгөл аймгийн Хатгал тосгон, Ханх сум, Хэнтий аймгийн Дадал сумуудын Хатуу хог хаягдлын байгууламжид автопүү, бүртгэлийн программ нийлүүлэх	399,985.8	379,986.5	100.0%
25	<b>1.3.1</b>	Хөвсгөл аймагт /Олон нийтийн оролцоотой худалдан авах ажиллагаа /ОНОХАА/	Зөвлөхөөс бусад бусдаар гүйцэтгүүлэх ажил	Жанхайн давааны худалдааны төвийн павильон, цайны газрын барилга угсралтын ажил	344,809.5	310,328.5	90.0%
26				Жанхайн давааны худалдааны төвийн явган зам, талбай, тохижилт, ногоон байгууламжийн ажил	207,000.0	60,605.1	40.0%
27				Жанхайн давааны худалдааны төвийн гадна цахилгаан, гадна болон дотор гэрэлтүүлгийн ажил	73,000.5	59,091.5	60.0%
28				Хатгал тосгон, жанхайн давааны худалдааны төвд суурилуулах хяналтын камер худалдан авах	18,000.0	18,000.0	100.0%

**3.5.4 Худалдан авах ажиллагааны гүйцэтгэл**

Тус төсөл нь тайлант онд шинээр худалдан авах ажиллагаа хийгдээгүй байна.

## **4. АУДИТЫН ТАЙЛАН**

### **4.1 Ерөнхий зүйл**

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана” гэж заасны дагуу Тогтвортой аялал жуулчлалыг хөгжүүлэх төслийн 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд аудит хийсэн төсөл, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, санхүүгийн тайлагналын үзэл баримтлал, аудитаар илрүүлсэн буруу илэрхийлэл, түүнийг шийдвэрлэсэн байдал, дараагийн аудитаар анхаарах асуудал болон аудиторын дүгнэлт, дүгнэлтийн үндэслэлийг хураангуйлан толилуулав.

Мөн орон нутгийн өмчид шилжүүлсэн барилга байгууламжийг данс бүртгэлээс хасах, анхан шатны баримтын бүрдэл, шилэн дансны тухай хуулийн хэрэгжилтийг хангахтай холбоотой өгсөн зөвлөмжийг тусгасан болно.

Аудитыг Бэйкер Тилли Далайван Аудит ХХК-ийн ахлах аудитор Ц.Бямбасүрэн, аудитор Э.Ариунзул аудиторын туслах Ц.Золзаяа нар гүйцэтгэж, чанарын хяналтын менежер М.Болормаа, компанийн ерөнхий захирал Ц.Жигдэн нар анхан шатны чанарын хяналтыг хэрэгжүүлж, Үндэсний аудитын газрын санхүүгийн аудитын газрын ахлах аудитор Б.Лхагвацэнд, аудитын менежер И.Эрдэнэцэцэг, газрын захирал, тэргүүлэх аудитор Ц.Наранчимэг нар тус тус хэрэгжүүлсэн.

Тогтвортой аялал жуулчлалыг хөгжүүлэх төслийн 2025 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Үндэсний аудитын газарт 2026 оны 01 дүгээр сарын 23-ны өдрийн 26/04 тоот албан бичгээр төслөөс ирүүлсэн байна.

### **4.2 Материаллаг байдал**

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр нийт зардлыг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэлийг “Дунд” гэж үнэллээ.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2025 оны санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардлын 1,477,162.9 мянган төгрөгөөс 1.0 хувиар буюу 14,771.6 мянган төгрөгөөр тогтоосныг аудитын явцад дахин хянаж шинэчлэн тогтоох шаардлагагүй гэж үзсэн.

### **4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт**

Төрийн хэмнэлтийн тухай хууль хэрэгжиж эхэлсэнтэй холбоотойгоор төсөл хэрэгжүүлэх нэгж нь цалин, нийгмийн даатгалын шимтгэл, байрны түрээс, бараа материал, урсгал засвар зэрэг зардлуудыг хэмнэж ажилласан байна.

### **4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал**

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайланд өгөх аудиторын дүгнэлтээс тусад нь салгах хэрэгтэй гэж заасан байна.

#### **4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт**

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг

Тогтвортой аялал жуулчлалыг хөгжүүлэх төслийн 2025 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

тогтоох журам"-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Шилэн дансны нэгдсэн цахим хуудсанд ил тод байршуулбал зохих цалингийн зардлаас бусад таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий 7,450.0 мянган төгрөгийн 1 мэдээлэл байршуулаагүй, хөрөнгийн зардал, хөрөнгө оруулалтын төсөл арга хэмжээний гүйцэтгэл, концессын зүйлийн жагсаалт гүйцэтгэлийн 4,6,10 сарын мэдээг хоосон оруулсан байна.

Энэ нь Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4 дахь Энэ хуулийн 3.1.1, 3.1.2-т заасан байгууллага дараах мэдээллийг долоо хоногийн дотор мэдээлнэ: 6.3.7 "хөрөнгө оруулалтын зарлага, санхүүжилтийг төсөл, объект тус бүрээр", 6.4.5 "цалингийн зардлаас бусад таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий орлого, зарлагын мөнгөн гүйлгээг гүйлгээ тус бүрээр, гүйлгээний агуулга, хүлээн авагчийн нэр;" гэсэн заалттай нийцэхгүй байна.

Шийдвэрлэсэн нь:

Шилэн дансны нэгдсэн цахим хуудаст ил тод байршуулбал зохих мэдээллийг байршуулаагүй зөрчлийг арилгаж, давтан гаргахгүй байх зөвлөмж өгөв.

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим сорилд үндэслэн шилэн дансанд байршуулсан мэдээлэл нь шилэн дансны тухай хууль тогтоомжийн холбогдох заалттай нийцээгүй гэж дүгнэлээ.

**4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт**

**4.5.1 Завсрын аудитын талаар**

Тогтвортой аялал жуулчлалыг хөгжүүлэх төслийн 2025 оны санхүүгийн тайланд завсрын аудит хийгдээгүй болно.

**4.5.2 Өмнөх аудитын мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний үр дүн**

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар шилэн дансны нэгдсэн цахим хуудсанд 65,232.5 мянган төгрөгийн 8 мэдээллийг байршуулаагүй зөрчилд албан шаардлага, бусад хууль тогтоомжийн хүрээнд худалдан авах ажиллагааны батлагдсан төлөвлөгөөнд тусгагдсан ажлыг хугацаанд нь хийж гүйцэтгэх 1 зөвлөмж өгснийг биелүүлж ажилласан байна.

Хүснэгт 4 Төлбөрийн акт, албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилт

/мянган төгрөгөөр/

Үзүүлэлт	Өмнөх аудитын үзүүлэлт		Биелэлт		
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Хувь
Албан шаардлага	1	65,232.5	1	65,232.5	100.0
Зөвлөмж	1	676,770.0	1	676,770.0	100.0
<b>Нийт дүн</b>	<b>2</b>	<b>742,002.5</b>	<b>2</b>	<b>742,002.5</b>	<b>100.0</b>

**4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал**

"Хатгалын төв замыг орон нутгийн аялал, жуулчлалын замтай холбох Хатгал-Жанхай-Тойлогт чиглэлийн авто зам, Хатгал-Хүзүүвчийн шил чиглэлийн авто зам, Хатгалын авто замын зогсоолын барилга"-ын ажлыг гүйцэтгэхээр 2021 оны 12 дугаар сарын 22-ны өдөр "Бээжин юни-констракшн групп" ХХК-тай 21/311 тоот гэрээг байгуулсан ба 2025 оны 03 дугаар сарын 31-ний өдөр гэрээний хугацаа дууссан. Уг гэрээт ажлын гүйцэтгэлийн баталгааны хугацаа мөн адил дууссан. Гэрээт ажлын гүйцэтгэл 50.0 хувьд ч хүрээгүй, ажлын төлбөрийн 60.0 хувь нь олгогдсон байгааг дараагийн аудитаар анхаарах асуудлаар орууллаа.

## 5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Аудитаар тайлант онд аялал жуулчлалын зориулалтаар баригдсан барилга байгууламж, зам тохижилтын дууссан 3,383,537.4 мянган төгрөгийн хөрөнгийн өртгийг төслийн санхүүгийн тайланд тусгаагүй алдаа<sup>1</sup> илэрснийг аудитын явцад залруулсан.

Аудитаар нийт 9,395,964.5 мянган төгрөгийн зөрчил<sup>2</sup> илэрсэнд 2 зөвлөмж хүргүүлээ.

Нийт илрүүлсэн алдаа, зөрчлөөс 9,395,964.5 мянган төгрөгийн залруулагдаагүй зөрчил нь бидний тогтоосон материаллаг байдлын 14,771.6 мянган төгрөгийн түвшнээс давсан тул "Хязгаарлалттай" дүгнэлт өглөө.

### 5.1 Зөвлөмж

**1.Илрүүлэлт:** Тайлант онд 44,491.6 мянган төгрөгийн зөвлөх үйлчилгээний ажлын хөлсийг цахим төлбөрийн баримтаар баталгаажуулаагүй, зардлаар хүлээн зөвшөөрч бүртгэсэн, төсөлд гэрээгээр ажилласан гаднын хяналтын инженер, хуулийн зөвлөх, түрээсийн жолооч нарт төслийн үйл ажиллагааны зардлаас 12,692.2 мянган төгрөгийн томилолтын зардал олгож, анхан шатны баримтын бүрдэл дутуугаар санхүүгийн тайланд тайлагнасан байна.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.7 дахь "Анхан шатны баримтын бүрдэлгүй ажил гүйлгээг бүртгэх санхүүгийн тайланд тусгахыг хориглоно", Сангийн сайдын 2017 оны 347 дугаар тушаалын 1 дүгээр хавсралтын 6.5 дахь "Төлбөрийн баримт нь бараа, ажил, үйлчилгээний төлбөр, тооцоо хийгдсэнийг нотлох анхан шатны цаасан болон цахим баримт"-г бүрдүүлэх гэсэн заалтуудтай нийцэхгүй байна.

**Өгсөн зөвлөмж:** Төлбөрийн цахим баримтыг үндэслэж, анхан шатны баримтыг бүрдүүлсний үндсэн дээр ажил гүйлгээг гүйцэтгэж, бүртгэл тайланд тусгаж байх

**2. Илрүүлэлт:** ТӨБЗГ-ын 2025 оны 05 дугаар сарын 22-ны өдрийн 253 дугаар тогтоолоор МОН-3787/3788 төслийн хүрээнд бий болсон 9,338,780.7 мянган төгрөгийн 19 ширхэг үндсэн хөрөнгийг Хэнтий, Хөвсгөл аймгийн орон нутгийн өмчид шилжүүлсэн ба төслийн бүртгэлээс хасаагүй байна. Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1 дахь "Аж ахуйн нээж, байгууллага нягтлан бодох бүртгэлийн дараах зарчмыг баримтална" 5.1.4-д "үнэн зөв байх" гэсэн заалтыг зөрчсөн байна.

**Өгсөн зөвлөмж:** Орон нутгийн өмчид шилжсэн хөрөнгийг 2026 оны эхний улиралд багтаан ашиглагч байгуулагад шилжүүлэх.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

<sup>1</sup> Мэдээллийг тусгахгүй орхигдуулах, буруу тусган илэрхийлэх, үүнд, математик үйлдлийн алдаа, НББ-ийн бодлогыг мөрдөхөд гарсан алдаа, бодит байдлыг буруу тайлбарласан /буруу ойлгосон/, хайнга хандсан /мартсан, тэмдэглээгүй орхисон/,

<sup>2</sup> Хүчин төгөлдөр үйлчилж буй хууль тогтоомжид харшлах байгууллага, түүний удирдлага, байгууллагад ажилладаг бусад хувь хүний санаатай болон санамсаргүй үйлдэл, эс үйлдэл.

## 6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

### 6.1. Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл

/мянган төгрөгөөр/

Алдааны товч утга	Нийт алдаа		Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан		Буруу тусган илэрхийлсэн		Үүнээс				Зөвлөмж	
							Залруулсан		Залруулаагүй			
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Тайлант онд ажил нь дууссан хөрөнгийг төслийн санхүүгийн тайланд тусгаагүй	1	3,383,537.4	1	3,383,537.4			1	3,383,537.4				
<b>Дүн</b>	<b>1</b>	<b>3,383,537.4</b>	<b>1</b>	<b>3,383,537.4</b>			<b>1</b>	<b>3,383,537.4</b>				

### 6.2. Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

/мянган төгрөгөөр/

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс									
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж		Хариуцлага тооцуулах албан шаардлага		Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудал	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Албан тушаалтны тоо	Тоо	Дүн
Тайлант онд зөвлөх үйлчилгээний ажлын хөлсийг цахим төлбөрийн баримтаар баталгаажуулаагүй, зардлаар хүлээн зөвшөөрч бүртгэсэн, төсөлд гэрээгээр ажилласан гадны инженер, хуулийн зөвлөх, түрээсийн жолооч нарт төслийн үйл ажиллагааны зардлаас анхан шатны баримтын бүрдэл томилолтын мөнгө олгосон	1	57,183.8					1	57,183.8				

Тогтвортой аялал жуулчлалыг хөгжүүлэх төслийн 2025 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

ТТӨБЗГ-ын тогтоолоор тайлант онд төслийн хүрээнд бий болсон 19 ширхэг хөрөнгийг Хэнтий, Хөвсгөл аймгийн орон нутгийн өмчид шилжүүлсэн ба төслийн бүртгэлээс хасаагүй байна.	1	9,338,780.7					1	9,338,780.7			
<b>Дүн</b>	<b>2</b>	<b>9,395,964.5</b>					<b>2</b>	<b>9,395,964.5</b>			

6.3.Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс <i>Имянган төгрөгөөр!</i>					
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой зөрчил								
Шилэн дансны нэгдсэн цахим хуудсанд ил тод байршуулбал зохих цалингийн зардлаас бусад таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий 7,450.0 мянган төгрөгийн 1 мэдээлэл байршуулаагүй, хөрөнгийн зардал, хөрөнгө оруулалтын төсөл арга хэмжээний гүйцэтгэл, концессын зүйлийн жагсаалт гүйцэтгэлийн 4,6,10 сарын мэдээг хоосон оруулсан.	1	7,450.0					1	7,450.0
<b>Дүн</b>	<b>1</b>	<b>7,450.0</b>					<b>1</b>	<b>7,450.0</b>